

ИМПОРТЫН ЭМИЙН ТҮРГЭВЧИЛСЭН БОЛОН ЭНГИЙН БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТУУД

1. Эм бүртгүүлэх байгууллагын албан хүсэлт, эмийн хэрэглээний явцад гарах чанар, аюулгүй байдлын баталгааны дүгнэлт, зах зээлийн дараах тандалт судалгаа хийх ажлын төлөвлөгөө;

Official request from the registrant company, conclusions relevant to quality, safety and quality assurance during product use, working plan on post marketing surveillance.

2. Үйлдвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан Монгол Улсад тухайн бүтээгдэхүүнийг бүртгүүлэх өргөдлийн эх хувь;

Original copy of application to register their product in Mongolia that is certified by the authorized representative of the manufacturer's name signature and seal;

3. Монгол Улсын эм ханган нийлүүлэх байгууллага эсхүл төлөөлөгчийн газар нь тухайн үйлдвэрлэгчтэй байгуулсан эм бүртгүүлэх гэрээний хуулбар хувь;

Original copy of contract made between the manufacturer and a wholesaling company in Mongolia or distributor to register their product in Mongolia

4. Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын гэрчилгээ (үйлдвэрлэгчийн баталгаажуулсан хуулбар);

Certificate of Good Manufacturing Practice (GMP) (certified copies of manufacturer);

5. Эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан эмийн бүтээгдэхүүний сертификатын эх хувь эсхүл албан ёсоор баталгаажуулсан хувь (ДЭМБ-ын жишгийн дагуу ба эмийн бүтээгдэхүүний тодорхойлолтыг хавсаргасан байх);

Original certificate of pharmaceutical products or verified copy of certificate by an authorized authority (shall include summary of product characteristics in accordance with WHO recommendation);

6. Үйлдвэрлэгч улсдаа бүртгэгдсэн бүртгэлийн гэрчилгээний хуулбар (бүртгэл нь хүчинтэй, хугацаа дуусаагүй гэрчилгээний хуулбарыг үйлдвэрлэгч эсхүл лиценз эзэмшигчийн тамга тэмдгээр баталгаажуулан ирүүлэх);

A copy of the registration certificate verifying that product is registered in the manufactured country (the registration shall be valid, the copy of the valid certificate shall be verified by the seal of the manufacturer or license holder);

7. Эмийн хяналтын хатуу зохицуулалттай эрх бүхий байгууллагатай улсад бүртгэгдсэн эсхүл бусад 5 улсад бүртгэгдсэн байдал (гадаадын улсад бүртгэгдсэн, бүртгэл нь хүчинтэй, хугацаа дуусаагүй гэрчилгээний хуулбарыг үйлдвэрлэгчийн тамга тэмдгээр баталгаажуулан ирүүлэх);

Registered in a country with stringent authority or registered in 5 different countries (product shall be registered in a different country, registration shall be valid, copies of valid certificate shall be verified by manufacturer's seal and submitted);

8. Үйлдвэрийн танилцуулга (CD-ээр үйлдвэрлэлийн процессыг харуулсан медиа хэлбэрээр, цаасаар 1-2 хуудсанд багтаан монгол хэлээр орчуулж ирүүлэх);
Introduction of the manufacturer (the production process shall be presented in a media form on CD-ROM, and 1-2 pages containing information regarding the production process that is translated into Mongolian shall be submitted);

9. Үйлдвэрлэгчийн эцсийн бүтээгдэхүүнд хийсэн шинжилгээний дүнгийн эх хувь, шинжилгээний аргачлал;
The original certificate of analysis for the finished product of the manufacturer and the method of analysis;

10. Үйлдвэрлэгчийн үндсэн үйлчлэгч болон туслах бодисыг шинжилсэн шинжилгээний дүн;
The certificate of analysis for the active ingredient and excipients of manufacturer

11. Бүтээгдэхүүний хадгалах хугацааг баталсан тогтвортой чанарын судалгааны дүн;
Stability test results proving the storage period and conditions;

12. Бүтэн цувралыг хамруулсан үйлдвэрлэлийн ажиллагааны заавар, үйлдвэрлэлийн процесс, схем (дамжлага дундын хяналтыг оруулах), вакцины хувьд нийт цувралын тэмдэглэл;
Production operating procedure, production protocol and scheme (including intermediate product control) for whole batch, summary lot protocol for vaccines

13. Ерөнхий нэршлийн эмийн хувьд биохүрэхүйн чанарыг тогтоосон судалгааны дүн (ДЭМБ-ийн зөвлөмжийн дагуу шаардлагатай эмийн хэлбэрт хийсэн судалгаа);
For generic medicines, proof bioequivalency test results (required for WHO recommended dosage formulations);

14. Вакцины хувьд олон улсад зөвшөөрөгдсөн лабораторийн шинжилгээний дүн болон тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон цувралыг чөлөөлсөн сертификат эсхүл тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон түүнтэй дүйцэхүйц баримт бичгийн баталгаажсан хувь;
For the vaccine, the tests results of internationally accredited laboratory and a lot release certificates issued by a competent authority or a certified copy of equivalent certificates issued by the competent authority of that country;

15. Эмийн хорон чанар (ерөнхий нэршлийн эмэнд хамаарахгүй), идэвх, аюулгүй байдлыг судалсан судалгааны дүгнэлт;
Toxicity of pharmaceutical product (not necessary for generic medicines), activity and safety study results;

16. Нийлмэл найрлагатай эмийн хувьд дан найрлагатай эмээс үйлдлийн идэвхээр илүү, аюулгүй болохыг тогтоосон судалгааны дүн;
For combination drugs, proof of quality, activity and safety inferiority over single drug;

17. Эмийн гадаад хэрэглэх заавар, Эм судлалын салбар зөвлөлөөр батлуулсан Монгол хувийн хамт;

Instruction for use (package insert list), accompanied by an approved Mongolian translation by the Subcommittee for Pharmacology;

18. Эмийн анхдагч болон хоёрдогч савлалтын өнгөт дэлгэмэл зураг, загвар дээж (Эмийг олгох нөхцөл, бүртгэлийн дугаар бичих талбарыг заасан байх);

Color printed primary and secondary package art work , medicine sample for registration (spaces designated for the condition for the pharmaceutical product and registration number shall be indicated);

19. Ажлын албатай гэрээ бүхий итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн (энэ заалт түргэвчилсэн бүртгэлд хамаарахгүй).

Test results performed by an accredited and contracted laboratory (it shall not apply for fast track registration).

20. Бүртгүүлэх эмийн үнийг дотоодын бөөний болон жижиглэнгийн үнэтэй харьцуулсан судалгаа;

Comparative study between the costs of registration product, wholesale and retail costs of locally manufactured products;

21. Бүртгүүлэгч байгууллагаас үндэсний үйлдвэрт үйлдвэрлэгддэг эмэнд хийсэн зах зээлийн эрэлт хэрэгцээ, хүртээмжийн судалгаа;

Survey on market demand and access of locally manufactured products by registrants;

22. Шаардлагатай тохиолдолд гадны итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний болон тээврийн төлбөрийн баримт;

Where necessary, evidence of payment for test analysis performed by external accredited laboratory and shipment fees for transportation;